



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/53/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Залруулсан алдаа	Error! Bookmark not defined.
4.2 Төлбөрийн акт	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага	14
4.3 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2/72

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D- alban bichig 2022 A4 TOOT

0050?039?

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,600,214.11	62,422,985.11
33	АВЛАГА	300,000.00	17,117,831.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	300,000.00	32,982.00
335	Бусад авлага	00.00	17,084,849.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	17,084,849.00
35	БАРАА МАТЕРИАЛ	29,300,214.11	45,305,154.11
351	Түүхий эд материал	11,720,800.00	14,352,800.00
35110	Тусгай зориулалттай материал	11,720,800.00	13,887,800.00
35130	Эм боох материал	00.00	465,000.00
354	Хангамжийн материал	17,579,414.11	30,952,354.11
35410	Бичиг хэргийн материал	2,601,600.00	2,046,600.00
35420	Аж ахуйн материал	14,977,814.11	14,639,914.11
35440	Түлш, шатах тослох материал	00.00	841,340.00
35460	Хүнсний материал	00.00	402,000.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	13,022,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,242,350,062.89	1,209,731,501.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,242,350,062.89	1,209,731,501.33
392	Биет хөрөнгө	1,229,924,062.85	1,195,555,501.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,147,255,162.28	1,147,255,162.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	-160,348,373.13	-200,232,909.21
39203	Авто-тээврийн хэрэгсэл	222,134,800.00	184,474,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-142,446,099.55	-128,623,132.71
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	167,266,997.00	191,341,417.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-135,247,932.26	-149,299,026.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,402,655.00	94,416,055.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-66,732,425.91	-71,619,138.27
39214	Бусад үндсэн хөрөнгө	223,656,892.00	287,692,183.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-136,613,112.58	-160,979,409.34
39216	Дуусаагүй барилга, байгууламж	20,000,000.00	00.00
39217	Ном	595,500.00	1,129,500.00
393	Биет бус хөрөнгө	12,426,000.04	14,176,000.08
39301	Програм хангамж	950,000.00	2,950,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-449,999.96	-699,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	11,926,000.00	11,926,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,271,950,277.00	1,272,154,486.44
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	282,500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	282,500.00
413	Өглөг	00.00	282,500.00
4136	Бусад өглөг	00.00	282,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	282,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,271,950,277.00	1,271,871,986.44
51	Засгийн газрын хувь оролцоо	1,271,950,277.00	1,271,871,986.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	230,672,223.16	230,672,223.16
51101	Өмч: - төрийн	230,672,223.16	230,672,223.16
512	Хуримтлагдсан үр дүн	1,024,478,555.88	1,024,400,265.32
51210	Өмнөх үеийн үр дүн	1,024,478,555.88	1,024,478,555.88
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-78,290.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,799,497.96	16,799,497.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,271,950,277.00	1,272,154,486.44

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	484,851,702.00	661,695,008.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,295,300.00	182,336,161.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,295,300.00	182,336,161.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,295,300.00	367,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	754,000.00	367,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	32,541,300.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	60,230,911.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	121,737,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	451,556,402.00	479,358,847.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	52,104,002.00	48,855,247.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	22,682,406.00	18,789,097.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,421,596.00	30,066,150.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	399,452,400.00	430,503,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	399,452,400.00	430,503,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	557,041,417.85	661,773,298.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	557,041,417.85	661,773,298.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	524,933,162.53	651,372,493.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,709,430.57	231,221,496.60
210101	Үндсэн цалин	229,709,430.57	231,221,496.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,259,656.34	30,005,056.00
210201	Тэтгэврийн даатгал	20,067,865.34	20,765,910.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,297,950.00	2,309,785.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,838,359.00	1,847,829.00
210204	Ажилгүйдлийн даатгал	459,589.00	461,958.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,595,893.00	4,619,574.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,716,017.00	18,312,148.79
210301	Гэрэл, цахилгаан	14,359,017.00	13,601,948.79
210302	Түлш, халаалт	8,357,000.00	4,710,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	84,876,234.00	190,029,848.00
210401	Бичиг хэрэг	8,826,640.00	5,063,820.00
210402	Тээвэр, шатахуун	33,715,989.00	37,398,003.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,496,000.00	2,673,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	230,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	38,477,605.00	139,380,225.00
210408	Бараа материал акталсны зардал	0	5,284,800.00
2105	Нормативт зардал	1,723,870.00	16,044,280.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0	10,430,000.00
210502	Хоол, хүнс	1,723,870.00	5,614,280.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,283,000.00	5,096,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,745,000.00	0
210604	Урсгал засвар	2,538,000.00	5,096,500.00
2107	Томилолт, зочны зардал	4,800,000.00	6,385,000.00
210702	Дотоод албан томилолт	4,800,000.00	6,385,000.00

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,354,401.00	26,351,491.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,408,401.00	24,927,491.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,000.00	0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	891,000.00	891,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,210,553.62	127,926,672.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,676,130.00	20,651,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	149,870.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	124,384,553.62	107,275,672.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,108,255.32	10,400,805.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,230,156.00	1,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,680,156.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	550,000.00	1,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,878,099.32	8,900,805.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,396,721.32	8,900,805.41
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	15,481,378.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-72,189,715.85	-78,290.56
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-72,189,715.85	-78,290.56

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	452,310,402.00	479,726,347.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	754,000.00	367,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	754,000.00	367,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	754,000.00	367,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	754,000.00	367,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	451,556,402.00	479,358,847.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	52,104,002.00	48,855,247.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,682,406.00	18,789,097.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,421,596.00	30,066,150.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	399,452,400.00	430,503,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	399,452,400.00	430,503,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	422,695,902.00	465,300,147.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	422,695,902.00	465,300,147.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	389,637,646.68	437,814,492.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	226,411,866.68	229,246,670.60
210101	Үндсэн цалин	218,817,366.68	187,260,412.34
210102	Нэмэгдэл	1,430,647.00	33,870,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	6,163,853.00	8,116,258.26

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,503,000.00	31,311,300.00
210201	Тэтгэврийн даатгал	21,465,100.00	22,268,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,259,800.00	2,260,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,807,200.00	1,808,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	451,900.00	452,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,519,000.00	4,521,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,024,699.00	19,179,148.79
210301	Гэрэл, цахилгаан	5,023,781.00	5,266,910.79
210302	Түлш, халаалт	16,000,918.00	13,912,238.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,750,800.00	31,738,167.00
210401	Бичиг хэрэг	4,629,100.00	3,135,170.00
210402	Тээвэр, шатахуун	22,821,500.00	20,752,497.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,290,200.00	1,154,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	6,117,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	650,000.00	578,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	950,000.00	1,482,300.00
210602	Тавилга	700,000.00	0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250,000.00	250,000.00
210604	Урсгал засвар	0	1,232,300.00
2107	Томилолт, зочны зардал	4,800,000.00	6,385,000.00
210702	Дотоод албан томилолт	4,800,000.00	6,385,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,506,824.00	38,538,189.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,530,324.00	35,378,689.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22,500.00	22,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,604,000.00	2,604,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,690,457.00	79,933,717.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,707,457.00	79,933,717.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	983,000.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,058,255.32	27,485,654.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,180,156.00	1,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,680,156.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,878,099.32	25,985,654.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,396,721.32	8,900,805.41
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	15,481,378.00	17,084,849.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	29,614,500.00	14,426,200.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	29,614,500.00	14,426,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,614,500.00	14,426,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,614,500.00	14,426,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,614,500.00	14,426,200.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-29,614,500.00	-14,426,200.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	230,672,223.16	16,799,497.96	1,096,668,271.73	1,344,139,992.85
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	230,672,223.16	16,799,497.96	1,096,668,271.73	1,344,139,992.85
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-72,189,715.85	-72,189,715.85
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	230,672,223.16	16,799,497.96	1,024,478,555.88	1,271,950,277.00
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	230,672,223.16	16,799,497.96	1,024,478,555.88	1,271,950,277.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	230,672,223.16	16,799,497.96	1,024,478,555.88	1,271,950,277.00
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-78,290.56	-78,290.56
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	230,672,223.16	16,799,497.96	1,024,400,265.32	1,271,871,986.44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	431,503,600.00	421,970,294.59	9,533,305.41	97.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	431,503,600.00	421,970,294.59	9,533,305.41	97.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	430,003,600.00	420,470,294.59	9,533,305.41	97.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,743,000.00	229,246,670.60	496,329.40	99.8
210101	Үндсэн цалин	187,671,000.00	187,260,412.34	410,587.66	99.8
210102	Нэмэгдэл	33,870,000.00	33,870,000.00	0.00	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	8,202,000.00	8,116,258.26	85,741.74	99.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,311,300.00	31,311,300.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	22,268,400.00	22,268,400.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,260,700.00	2,260,700.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,808,600.00	1,808,600.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	452,200.00	452,200.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,521,400.00	4,521,400.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,784,700.00	19,179,148.79	605,551.21	96.9
210301	Гэрэл, цахилгаан	5,267,000.00	5,266,910.79	89.21	100.0
210302	Түлш, халаалт	14,517,700.00	13,912,238.00	605,462.00	95.8
2104	Хангамж, бараа материалын зардал	32,408,100.00	32,272,167.00	135,933.00	99.6
210401	Бичиг хэрэг	3,369,700.00	3,369,170.00	530.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	20,754,500.00	20,752,497.00	2,003.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,213,900.00	1,154,200.00	59,700.00	95.1
210404	Ном, хэвлэл	350,000.00	300,000.00	50,000.00	85.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,120,000.00	6,117,800.00	2,200.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	578,500.00	21,500.00	96.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,909,400.00	9,114,500.00	3,794,900.00	70.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,732,000.00	6,728,800.00	3,200.00	100.0
210602	Тавилга	3,695,000.00	903,400.00	2,791,600.00	24.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250,000.00	250,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	2,232,400.00	1,232,300.00	1,000,100.00	55.2
2107	Томилолт, зочны зардал	6,831,000.00	6,385,000.00	446,000.00	93.5
210702	Дотоод албан томилолт	6,831,000.00	6,385,000.00	446,000.00	93.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,276,500.00	8,767,791.20	508,708.80	94.5

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,100,000.00	5,608,291.20	491,708.80	91.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22,500.00	22,500.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	33,000.00	17,000.00	66.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,604,000.00	2,604,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,739,600.00	84,193,717.00	3,545,883.00	96.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,739,600.00	84,193,717.00	3,545,883.00	96.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	431,503,600.00	421,970,294.59	9,533,305.41	97.8
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	430,503,600.00	421,602,794.59	8,900,805.41	97.9
320001	Орон нутгийн төсвөөс	430,503,600.00	421,602,794.59	8,900,805.41	97.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	367,500.00	632,500.00	36.8
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	367,500.00	632,500.00	36.8
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	43	43	0.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21	0.00	
620001	Удирдах ажилтан	8	8	0.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11	0.00	
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0.00	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21	21	0.00	
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8	0.00	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	6	0.00	
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7	0.00	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,622,624.00	31,770,398.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,622,624.00	31,770,398.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,622,624.00	31,770,398.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,622,624.00	31,770,398.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,622,924.00	31,770,398.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	36,622,624.00	31,770,398.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,622,624.00	31,770,398.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,452,142.00	18,789,097.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,170,482.00	12,981,301.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн ба төсвийн зарцуулалтын эрхийн хүсэлтэд нэгдүгээр гарын үсгийг дарга Р.Гантулга, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Дэлгэрдалай нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэдэд хүнд сурталгүй, аливаа чирэгдэлгүй, хурдан шуурхай үйлчлэх явдлыг хэвшүүлж, эдийн засаг нийгмийн бусад хөтөлбөрүүдтэй нягт уялдсан цэгцтэй, уян хатан бөгөөд үр ашигтай үйлчилгээг бий болгоно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 557,041.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,355.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,848.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 9,926.6 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдал 6,948.6 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 204.2 мянган төгрөгөөр буюу 0.02 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,600.2	62,423.0	32,822.8
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	300.0	17,117.8	16,817.8
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	29,300.2	45,305.2	16,004.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,242,350.1	1,209,731.5	(32,618.6)
Үндсэн хөрөнгө	1,884,188.0	1,921,185.1	36,997.1
Хуримтлагдсан элэгдэл	(641,837.9)	(711,453.6)	(69,615.7)
Нийт хөрөнгө	1,271,950.3	1,272,154.5	204.2
Өр төлбөр	-	282.5	282.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,271,950.3	1,271,872.0	(78.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,271,950.3	1,272,154.5	204.2

Авлагын дансны үлдэгдэл 16,817.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй үлдэгдэл болох 17,084.8 мянган төгрөгийг тайлант оны авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 45,305.2 мянган төгрөг болж 16,004.9 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 13,887.8, эм боох материал 465.0 мянга, хангамжийн материал 13372.9 мянган төгрөгөөр өссөн бөгөөд, бусад хангамжийн материал дансанд 57,988.4 мянган төгрөгийн үнэ төлбөргүй өвс тэжээл хүлээн авч зарцуулсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,921,185.1 мянган төгрөг болж өмнөх оноос 36,997.1 мянган төгрөгөөр өссөн нь 13,426.0 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, Гурванбулаг сумын ИТХ-ын 2021.12.17-ны өдрийн 6/03 дугаар тогтоолоор 41758.9 мянган төгрөгийн хөрөнгө, Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын 2021.06.07-ны өдрийн 01/594 дугаар албан бичиг 4,272.6 мянган төгрөгийн өртөг бүхий "Хур систем"-ийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч, Гурванбулаг сумын ИТХ-ын 2020.04.10-ны өдрийн 13 дугаар тогтоолоор УАЗ-469 маркийн автомашины дуудлага худалдаанд оруулж, данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,271,872.0 мянган төгрөг болж 78.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 78.3 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд төсвийн нийт эх үүсвэрийг 577,056.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 176,283.3 мянган төгрөгөөр бууруулж 400,773.5 мянган төгрөгөөр анх батлагдаж 2 удаа тодотгож 431503.6 мянган төгрөгөөр батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг 431,503.6 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 430,503.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 367.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 421,970.3 мянган төгрөгийг зарцуулж 8,900.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 421,970.3 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшлын зардлыг 496.3 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 605.6 мянга, хангамж бараа материалын зардлыг 135.9 мянга, эд хогшил урсгал засварын зардал 3,794.9 мянга, томилолтын зардлыг 446.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 508.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 3,545.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой дараах алдаа, зөрчил илэрсэн ба тус алдаа, зөрчлүүдийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар **арилгаж** нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандартын дагуу бүртгэсэн байна. Үүнд:

- Засаг даргын захирамжаар өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор 28656.0 мянган төгрөгийн өвс тэжээл бэлтгэснээс гамшгаас хамгаалах, сэргийлэх, сургалт сурталчилгааны зардлаас 13662.0 мянган төгрөгийг төлж, тус сумын нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг "Жи энд юу гоулд" ХХК-ны хандиваар орсон 26588.0 мянган төгрөгийн хандиваас 14994.0 мянган төгрөгийг төлсөн байна. Тус компанийн хандивын үлдэгдэл болох 11594.0 мянган төгрөгөөр өвс тэжээл худалдан авсан байгаа боловч нягтлан бодох бүртгэлд тусгаагүй.
- Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар хийгдсэн 2386.0 мянган төгрөгийн автомашины засварын үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүйгээс санхүүгийн программ дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл зөрүүтэй.
- Засаг даргын 2021.02.05-ны өдрийн 32 дугаар захирамжаар өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор 28656.0 мянган төгрөгийг гамшгаас хамгаалах, сэргийлэх, сургалт сурталчилгааны зардлаас гарган зарцуулахаар зардлын ангиллыг зааж өгсөн байхад 6000.0 мянган төгрөгийг багсармал тэжээл, малын тэжээл, 4656.0 мянган төгрөгийн тэжээлийн будааг тус тус Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулсан байна.
- Сангийн яамны Э-тайланд шивж баталгаажуулсан 3-р улирлын санхүүгийн байдлын тайланг санхүүгийн программд бүртгэсэн тайлантай тулган шалгахад эцсийн үлдэгдэл 256.9 мянган төгрөгөөр зөрүүтэй.
- Санхүүгийн тайланд байгаа эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг эд хариуцагчийн тайлантай тулган шалгахад нярав түлш шатахууны тайланг жолоочийн тооцооны хуудсаар бүрэн гаргаагүй, бусад хангамжийн материалын тайланг зөрүүтэй гаргаснаас нийт орлого 125.0 мянга, зарлага 125.0 мянган төгрөгөөр зөрүүтэй.
- Мал тооллогын тоологчийн цалинг НДХ-т мэдээлээгүйгээс нийт 382.3 мянган төгрөгийн зөрүү үүссэн, мөн ХХОАТ 72.5 мянга, НД-д 91.9 мянган төгрөгийг санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан зөрчлийг арилгасан байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд нийт 96 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 91.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 661,773.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 104,731.9 мянган төгрөгөөр буюу 18.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд, хангамж бараа материалын зардал, нормативд зардал, дотоод албан томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эд хогшил худалдан авах зардал, бараа үйлчилгээний бусад зардал нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 534,933.8 мянган төгрөгийн 44 мэдээллээс хуулийн 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 17,084.8 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг хугацаа хоцроосон байна

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- 2021 оны төсвийг 400,773.5 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 30,730.1 мянган төгрөг нэмж 430,503.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 421,970.3 мянган төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 8,900.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байгаа нь нийт зардлын 2.1 хувийг хэмнэсэн гэж үзэхээр байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1¹ гэсэн заалттай нийцэхгүй байна.

- Бичиг хэргийн зардлыг 3,369.7 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 3,369.2 мянган төгрөг зарцуулсан байна.

- Албан томилолтын зардлыг 6,831.0 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 6,385.0 мянган төгрөг зарцуулсан нь батлагдсан төсөвт 6.5 хувийн хэмнэлт гаргасан.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 22,773.0 мянган төгрөгөөр, тодотголоор 19,784.7 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 19,179.1

1. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах

мянган төгрөг зарцуулж, анх баталсан дүнгээс 3,593.9 мянган төгрөг буюу 15.8 хувь хэмнэсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 16,329.5 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 4,172.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 12,157.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 147,004.0 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс 352.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 139,307.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 7,345.3 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг хүргүүлээ.

4.1 Төлбөрийн акт

1. Засаг даргын 2021.02.09-ний өдрийн 38 дугаар захирамжаар 2020 оны аймаг сумын аварга малчин, мал аж ахуйн салбарт шалгарсан малчдыг шагнаж урамшуулах 5000.0 мянган төгрөг зарцуулах шийдвэр гарсан ч 352.0 мянган төгрөгийг архинаас гарсан иргэдийг шагнаж урамшуулж зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын нийтлэг журам”-ын 7.1 “Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс илүү зарцуулсан 352,0 мянган төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнуудаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.2 Албан шаардлага

1. Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь Хаан банкин дахь 5237001000 тоот харилцах дансаар тайлант оны 2021.11.25-ны байдлаар 71,680.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банканд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ”, 35.4 дэх “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бичгээр ирүүлсэн зөвшөөрөлгүйгээр банк аливаа төсвийн байгууллагад данс нээхийг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Арилжааны банкин дахь харилцах дансыг хааж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2. Тайлант хугацаанд Засаг даргын захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгө, байгаль орчныг нөхөн сэргээх зардал болон гамшгаас сэргийлэх, сургалт сурталчилгааны зардлаас зарцуулсан 67,626.9 мянган төгрөгийн зарцуулалтын тайланг гаргаж үр дүнг тооцоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7 дахь “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын

нийтлэг журам"-ын 6.2 дахь "Нөөц хөрөнгийн зарцуулалтын тайланг санхүүжүүлсэн зардал, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөвтэй зэрэгцүүлэн гаргаж, байгууллагын дарга, нягтлан бодогч нар гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулан холбогдох баримтыг хавсаргана" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгө, байгаль орчныг нөхөн сэргээх зардал болон гамшгаас сэргийлэх, сургалт сурталчилгааны зардлаас зарцуулсан 67,626,867 /Жаран долоон сая зургаан зуун хорин зургаан мянга найман зуун жаран долоон/ төгрөгийн хөрөнгийн зарцуулалтын тайланг гаргаж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4.3 Зөвлөмж

1. Тайлант хугацаанд 2290.3 мянган төгрөгийн 2 гүйлгээг и баримт болон анхан шатны баримтын бүрдэлгүй, 3721.7 мянган төгрөгийн 16 гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй, мөн хувь хүн рүү шилжүүлсэн зарим гүйлгээг 10 хувийг суутгаагүй, зарим сард төрийн санд гүйлгээ хийхдээ нэгдүгээр гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтын гарын үсэггүйгээр гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5. Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Сангийн сайдын 2017 оны "Маягт, заавар батлах тухай" 347 дугаар тушаалын холбогдох заалтыг мөрдөж ажиллаж байгаад удирдлагын зүгээс хяналт тавьж ажиллах.

2. Тайлант хугацаанд аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардлаас сонины төлбөрт 87.7 мянга, лицензийн төлбөрт 198.0 мянга, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас 75.0 мянган төгрөгийн автомашины татвар хураамж, аудит баталгаажуулалтын зардлаас туг далбааны үнэ болох 117.6 мянга, гэрэл цахилгааны зардлаас 605.0 мянган төгрөгийн халаагуурын үнэ, хөдөлмөр хамгааллын зардлаас ЗДТГ-ын жолоочид 250.0 мянган төгрөгийн гутал худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолоор баталсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар" тай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар" -ыг бүрэн мөрдөж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

3. Тайлант хугацааны Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг тулгахад тус сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн 97, 2021 оны 09 дүгээр сарын 02-ний өдрийн 123, 2021 оны 05 дугаар сарын 28-ний өдрийн 82, 2021 оны 06 дугаар сарын 27-ний өдрийн 85 дугаар захирамж нь хүчингүй болсон журмыг үндэслэн гаргасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид байгууллагын удирдлага нь хүчин төгөлдөр хууль эрхзүйн актыг мөрдөж байх зөвлөмжийг хүргүүлэв.

4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 17,084.8 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулж байх зөвлөмжийг өгөв.

5. 2021 оны төсвийг 400,773.5 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 30,730.1 мянган төгрөг нэмж 430,503.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 421,970.3 мянган төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 8,900.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байгаа нь нийт зардлын 2.1 хувийг хэмнэсэн гэж үзэхээр байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар Засгийн газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар өгсөн зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар	8	147,004.0			1	352.0	2	139,307.1	5	7,345.3

_____оОо_____